


МОНГОЛЫН НИЙГМИЙН САЙН САЙХАН БАЙДЛЫН СУДАЛГАА

ЭМЧ, ЭМНЭЛЭГИЙН БАЙГУУЛЛАГАД АЖИЛЛАГСДЫН САЙН САЙХАН БАЙДЛЫН СУДАЛГАА



НИЙГМИЙН НИЙЦЭЛ

АМЬДРАЛЫН ОЛОН ТАЛТ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

АМЬДРАЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖ

АМЬДРАЛЫН УТГА УЧРЫН, ҮНЭЛГЭЭ

Хараат бус судалгааны хүрээлэн (IRIM) нь Монгол Улсад мэргэжлийн, хараат бус судалгааг институтийн түвшинд, тогтвортой хэрэгжүүлж буй анхны байгууллагуудын нэг юм. Бид олон нийтэд хараат бус, чанартай мэдээллийг түгээж, сайн сайхан нийгмийг цогцлоох, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хоорондын хамтын ажиллагааг дэмжих, Монголын хүн амын хэрэгцээнд нийцсэн шинэлэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зорьж байна. IRIM нь “Азийн Нийгмийн сайн сайхан байдлын консорциум” болон “Олон улсын Социологийн холбоо”-ны гишүүн юм.

Бидэнтэй холбогдох

Цахим шуудан: contact@irim.mn

Фейсбүүк/ Твиттер хуудас: @IRIMongolia

Вэбсайт: www.irim.mn

Тайланг эш татах

IRIM (2021), “Монголын нийгмийн сайн сайхан байдлын судалгаа: Эмч, эмнэлгийн байгууллагад ажиллагсдын сайн сайхан байдал” Улаанбаатар. IRIM судалгааны хүрээлэн

Тайлан бичсэн

Ууганбаатарын Дагийсүрэн, Түйгомбын Пүрэвсүрэн, Лхагваноровын Дашзэвэг

Хянасан

Цэвэгдоржийн Болд, Алдарын Долгион

Мэдэгдэл

Энэхүү тайлангийн агуулга нь судалгааны багийн гаргасан дүн шинжилгээний үр дүн ба IRIM судалгааны хүрээлэнгийн албан ёсны байр суурийг төлөөлөхгүй болно.

Тайланг түгээх, дамжуулах, татаж авах болон хэвлэх боломжтой бөгөөд IRIM судалгааны хүрээлэнгийн эх сурвалж ба зохиогчийн эрхийг зохих ёсоор дурдаж тайлангийн хэсгээс эшлэл татаж болно.

Агуулга

Удиртгал	5
Судалгааны арга зүй	7
Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл	
Эмч, эмнэлгийн байгууллагын ажилтнуудын нийгмийн сайн сайхан байдал	
Нийгмийн нийцэл	10
Амьдралын сэтгэл ханамж	10
Амьдралын олон талт байдлын үнэлгээ	13
Амьдралын утга учрын талаарх үнэлгээ	
Ном зүй	

Удиртгал



Сүүлийн хорь гаруй жилийн турш нийгмийн сайн сайхан байдлын бүрдэл хэсэг болох субъектив сайн сайхан байдлыг хэмжих, үнэлэх онолын ба практик боломж олон улсад нэмэгдсээр байна. Нийгмийн сайн сайхан байдлыг хэмжихэд ийнхүү дэлхий нийтээрээ ахиц гаргаж байгаа ч Монгол Улсын хувьд энэ талаар тогтвортой, үндэсний хэмжээнд хийгддэг судалгааны ажил хомс байна. Энэ нь манай улсад нийгмийн хүчин зүйлсийг харгалзсан төрийн бодлого, шийдвэр гаргалт учир дутагдалтай байгааг илтгэнэ.

IRIM судалгааны хүрээлэнгийн бие даасан бүтээгдэхүүн болох “Нийгмийн сайн сайхан байдлын судалгаа” 5 дахь жилдээ хийгдэж, судалгааны тайлангаа уншигч таны гар дээр тавьж байна. Уг судалгаа нь нийгмийн хөгжилд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаарх ойлголтыг сайжруулахад тусалж, баримт нотолгоонд тулгуурласан шийдвэр гаргалтыг дэмжихэд хувь нэмрээ оруулах зорилготой.

Монголын нийгмийн сайн сайхан байдлын судалгааны мэдээлэл цуглуулалтын ажлыг 2016-2019 оны хооронд жил бүр өөр өөр цаг хугацаа, цаг үеийн ялгаатай мөчлөгүүдийн харгалзан цуглуулсан бөгөөд 2020 оноос хойш хийгдэж буй нийгмийн тодорхой бүлгийн сэдэвчилсэн судалгааны гол харьцуулах үзүүлэлт болгон ашигладаг.

Өнгөрсөн 2020 онд “Ахмад настнуудын нийгмийн сайн сайхан байдал” сэдэвчилсэн судалгааны ажлыг гүйцэтгэж үр дүнг олон нийтэд танилцуулсан бол 2021 онд эрүүл мэндийн салбарын ажиллагсдыг судалгааны зорилтот бүлгээр сонгосон. Зөвхөн Монголд төдийгүй дэлхийн олон улс оронд сүүлийн 1-2 жилийн хугацаанд COVID-19 цар тахлын хүнд цаг үед эмнэлгийн байгууллагын ачаалал, ажлын цаг эрс нэмэгдэжэмч, эмнэлгийн байгууллагын ажилтнуудын ажил, амьдралын тэнцвэр, нийгмийн асуудал амаргүй байлаа.

Удиртгал

Тодруулбал манай улсын эмч, эмнэлгийн байгууллагын ажилтнууд энэ оны 7 дугаар сард ажлын нөхцөл, хангамжаа сайжруулах зорилгоор төв талбайд тайван суулт хийж, эсэргүүцлээ илэрхийлсэн. Тухайн эсэргүүцлийн үеэр эмч, эмнэлгийн байгууллагын ажилтнууд ажлын ачаалал, эрсдэлт нөхцөл байдалд ажиллаж буй байдлаа харгалзан цалин хангамжаа 2 дахин нэмэгдүүлэх шаардлага хүргүүлсэн ч тодорхой үр дүнд хүрээгүй. Мөн оны 9 дүгээр сард ЭМЯ-ны захиалгаар гүйцэтгэгдсэн “Цар тахлын цаг үед эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг үнэлэх судалгаа”-ны үр дүнгээр эмч, эмнэлгийн байгууллагын ажилтнуудын 70 орчим хувьд стрессээс үүдэлтэй сэтгэл гутралын эмгэг, 10 орчим хувьд ажлаас халшрах хам шинж илэрсэн гэжээ.

Энэхүү сэдэвчилсэн судалгааны мэдээлэл цуглуулалтыг 2021 оны 12 дугаар сарын 01-ны өдрөөс 12 дугаар сарын 10-ны хугацаанд Улаанбаатар хотод байршилтай эмнэлгийн байгууллагад ажиллагсдаас түүвэрлэн гүйцэтгэсэн. Энэ цаг хугацаанд COVID-19 цар тахлын шинэ хувилбар (Омикрон хувилбар)-ын ид тархалт таарсан бөгөөд эмч, эмнэлгийн байгууллагын ажиллагсдын маш өндөр ажлын ачаалалтай үе байсныг онцлох нь зүйтэй.

Эрүүл мэндийн салбарт ажиллагсад энэ бэрхшээлтэй цаг үед тэд өөрсдийн субъектив сайн сайхан байдал болон хүрээлэн буй нийгмээ хэрхэн үнэлж буйг тодорхойлсон нь салбарын нөхцөл байдлыг бүрэн дүр зургаар харах, оновчтой шийдвэр, алхмуудыг тодорхойлоход багагүй хувь нэмэр үзүүлнэ гэж итгэж байна.

Судалгааны арга зүй

Эмч, эмнэлгийн байгууллагын ажилтнуудын нийгмийн нийцэл, сайн сайхан байдлын түвшнийг тодорхойлж, үндэсний хэмжээнд гүйцэтгэгдсэн суурь судалгаа (цаашид “улсын дундаж” гэсэн нэршлээр ашиглагдана)-ны үр дүнтэй харьцуулан танилцуулах зорилготой.

Судалгааны мэдээлэл цуглуулалтад ашигласан асуулгын хүрээг дараах байдлаар гаргасан.

Судалгааны хүрээнд нийт 4 бүлэгт хамаарах 54 асуулт асуугдсан бөгөөд 2 бүлэг 20 гаруй асуулт нь судалгааны үндсэн үр дүнг илэрхийлж, бусад асуултууд нь харьцуулагдах үр дүнг

дэмжих, харьцуулагдах байдлаар тайланд туссан.

Судалгааны үндсэн асуултуудад 0-10 хүртэлх 11 сонголт бүхий Кантрил (Cantril, 1965)-ын шкалыг ашигласан бөгөөд ихэнх тохиолдолд үндсэн үр дүнг эдгээр 11 шкалын дундаж утгаар илэрхийлсэн.

Энэхүү аргачлал хүмүүс хоорондын итгэлцэл, хамтын ажиллагаа, сайн сайхан байдлын хэмжээсийг илэрхийлэхэд олон улсад хамгийн өргөн хэрэглэгдэж байна. Ингэснээр ижил төстэй олон улсын судалгаатай үр дүнгээ харьцуулах боломжийг бий болгосон.

Хүснэгт 1. Судалгааны асуумжийн агуулгын хүрээ

№	Бүлэг	Бүрэлдэхүүн хэсэг	Асуултын тоо
1	Судалгаанд оролцогчдын ажлын байр, түүний орчин нөхцөлтэй холбогдох мэдээлэл (харьцуулагдах мэдээлэл)		12
2	Хүн ам зүйн ерөнхий мэдээлэл (Харьцуулагдах мэдээлэл)	Судалгаанд оролцогчийн ерөнхий мэдээлэл	4
3		Өрхийн ерөнхий мэдээлэл	4
4	Нийгмийн нийцэл (Гол хувьсагч) Амьдралын сайн сайхан байдал	Итгэлцэл	11
		Амьдралын сэтгэл ханамж	7
		Амьдралын олон талт үнэлгээ	8
		Амьдралын утга учир	8

Хүснэгт 2. Судалгааны үндсэн асуултуудад ашиглагдсан шкалын төрөл



Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

Судалгаанд 380 эмч болон эмнэлгийн байгууллагад ажиллагсад хамрагдаж, өөрсдийн үзэл бодлоо илэрхийлсэн. Үүнээс:


- Судалгаанд нийт 21-67 насны хүмүүс оролцсон бөгөөд 35-40 насны оролцогчид дийлэнх байна.
- Судалгаанд оролцогчдын 80 орчим хувь нь эмэгтэйчүүд, 60 гаруй хувь нь дээд боловсролтой хүмүүс байв.
- Судалгаанд оролцогчдын 70 орчим хувь нь гэрлэсэн, 90 гаруй хувь нь 2 ба түүнээс өрхийн гишүүдтэй гэр бүлд амьдардаг байна. Тэд 7 хоногт

дунджаар 52 цагийг гэр бүлтэйгээ өнгөрүүлж буй бөгөөд COVID-19-ын нөхцөл байдлын улмаас гэр бүлдээ гаргах цаг маш багассан гэдэгтэй бүрэн санал нэгдэж байв.

- Судалгаанд оролцогчдын 70 орчим хувь өөрсдийгөө нийгмийн дундаж давхаргад хамаатуулж үзэж байгаа ба тал хувь нь “сүүлийн 2 жилийн хугацаанд өөрсдийн амьжиргааны түвшинд төдийлөн өөрчлөлт гараагүй” гэжээ.

Дүрс 1. Судалгаанд оролцогчдын хүн ам зүйн мэдээлэл

Хүйс




Боловсролын түвшин




Гэрлэлтийн байдал




Өрхийн гишүүний тоо



Сүүлийн 2 жилд танай өрхийн амьжиргааны түвшин хэрхэн өөрчлөгдсөн бэ?



Та өөрийгөө ямар давхраанд хамааруулан үздэг вэ?



Судалгаанд оролцогчдын ажлын орчин, нөхцөл

Судалгаанд 380 эмч болон эмнэлгийн байгууллагад ажиллагсад хамрагдаж, өөрсдийн үзэл бодлоо илэрхийлсэн. Үүнээс:

- Улсын статустай эмнэлэгт ажиллагсад дийлэнх хэсгийг буюу 85 орчим хувь байна.
- Эмнэлгийн байгууллагын төрлөөр нь авч үзвэл “нэгдсэн эмнэлэг”, “төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг”-үүдэд ажиллагсад зонхилж байна.
- Судалгаанд оролцогчдын 3 хүн тутмын 1 нь эмч нар, мөн 3 хүн тутмын 1 нь сувилагч нар байгаа бол үлдсэн хэсгийг эмнэлгийн байгууллагын захиргаа, үйлчилгээний ажиллагсад бүрдүүлсэн.
- Судалгаанд оролцогчид дунджаар эмнэлгийн салбарт 9.8 жил, одоогийн ажиллаж буй эмнэлэгтээ 6.9 жил ажилласан туршлагатай байна.
- Судалгаанд оролцогчид 7 хоногт дунджаар 50 цаг ажиллаж байгаа ба талаас илүү хувьд нь COVID-19-ын нөхцөл байдлаас шалтгаалан ажлын цаг нь эрс нэмэгдсэн байна.

Оролцогчдын 75 хувьд ачаалал, ажлын цаг нэмэгдсэн бол 5 орчим хувьд нь ажлын цаг багассан байна.


- Судалгаанд оролцогчид сард дунджаар 813,240 төгрөгийн цалинтай ажиллаж байна. COVID-19-ын нөхцөл байдлаас шалтгаалан 40 орчим хувь нь ямар нэгэн байдлаар нэмэгдэл цалин авсан бол талаас илүү хувийнх нь цалинд ямар нэгэн өөрчлөлт гараагүй байна.
- Судалгаанд оролцогчдын тал хувь өөрсдийн ажилладаг эмнэлгийн орчин нөхцөлийг “сайн” гэж, 40 хувь нь “дунд зэрэг” гэж үнэлсэн бөгөөд COVID-19-ын нөхцөлд ажиллах аюулгүй байдлаа бүрэн хангагдсан гэж 30 орчим хувь нь үзжээ. Аюулгүй байдлаа бүрэн хангагдаж чадаагүй гэж хариулт өгч буй ажилтнуудын ихэнх нь улсын статустай эмнэлгийн байгууллагад ажиллагсад байна.




Судалгаанд оролцогчдын ажлын орчин, нөхцөл

Дүрс 2. Судалгаанд оролцогчдын ажлын орчин, нөхцөлтэй холбоотой үр дүн

Ажилладаг эмнэлгийн төрөл



Эмнэлгийн байгууллага, төрлөөр



Ажилласан жил, төрлөөр, дунджаар



Оролцогчийн албан тушаал




COVID-19-ын нөхцөл байдалтай холбоотой ажлын цагт өөрчлөлт гарсан эсэх



COVID-19-ын нөхцөл байдалтай холбоотой цалинд өөрчлөлт гарсан эсэх





**ЭМЧ, ЭМНЭЛГИЙН
БАЙГУУЛЛАГЫН
АЖИЛТНУУДЫН
НИЙГМИЙН САЙН
САЙХАН БАЙДАЛ**

Нийгмийн нийцэл



Дараах ерөнхий 1 асуултаар судалгаанд оролцогчдын бусдад хэр итгэдэг болохыг тодруулсан.

'Ерөнхийд нь авч үзвэл бусад хүмүүст итгэж болно гэж боддог уу?' эсвэл маш болгоомжтой харилцах шаардлагатай гэж боддог уу? (0=Хүмүүс ихэнхдээ бие биедээ тусархаг байдаг; 10=Хүмүүс ихэнхдээ өөрсдийгөө дор дороо болгодог)

- Судалгаанд хамрагдсан эмч, эмнэлгийн ажилчдын дундаж ерөнхий итгэлийн түвшин 4.9 байв. Энэ нь улсын дундаж үр дүнгээс 1.76 функтээр бага байна. Өөрөөр хэлбэл бусдад итгэх тал дээр эмнэлгийн байгууллагад ажиллагсад нийт Монголчуудтай харьцуулахад илүү болгоомжтой хандаж байна.

- Эмч нар бусад хүмүүст хэт их итгэх эсвэл хэт итгэхгүй байхаас илүүтэй дундаж хариултын утгуудыг түгээмэл сонгож байсан ба 5 ба түүнээс бага функтыг нийт Монголчуудтай харьцуулахад илүү өндөр сонгож, эсрэгээр 5 ба түүнээс дээш функтыг илүү бага сонгосон үр дүн харагдлаа.
- Судалгаанд оролцогчдын бусдад итгэх байдлыг илтгэсэн судалгааны үр дүнд тэдний ажлын нөхцөл болон хүн ам зүйн мэдээллээс нь хамаарсан ялгаатай байдал ажиглагдсангүй. Тухайлбал тэдний ажилладаг байгууллагын статус, албан тушаал, цалин, ажлын цаг, нас, хүйс, боловсролын түвшин зэргээр статистик тест хийж үзэхэд ач холбогдол бүхий ялгааг харуулсангүй.

Дүрс 3. Судалгаанд оролцогчдын хариултын дундаж




Нийгмийн нийцэл

Итгэлцлийн талаар нарийвчлан тайлбар өгөхийн тулд бид судалгаандаа нийгмийн ерөнхий итгэлцэл болон нийгмийн тухайлсан итгэлцлийн аль алиных нь статусыг тодорхойлохыг зорьсон. **Та нийгмийн өөр өөр бүлгийн хүмүүст хэр зэрэг итгэдэг вэ?** (0=Огт итгэдэггүй; 10=Бүрэн итгэдэг)

- Судалгаанд оролцогчид танихгүй хүмүүст (2.84) хамгийн бага, харин өөрийн гэр бүлийнхэнд (8.36) хамгийн их итгэдэг болохоо илэрхийлжээ.
- Эмнэлгийн байгууллагад ажиллагсадын хувьд ойрын хүрээлэл буюу гэр бүл хамаатан садан, хамтран ажиллагсад, хөршүүддээ итгэх итгэл бусад нийгмийн бүлгүүдтэй харьцуулахад өндөр байна. Энэхүү үр дүнг үндэсний хэмжээний үр дүнтэй харьцуулахад ерөнхий дүр зураг нь ижил боловч бүлэг бүрд итгэх итгэл нь 2 орчим функтээр бага байв.
- Судалгаанд оролцогчид эзэмшсэн боловсролын түвшнээсээ хамааран нийгмийн зарим бүлэгт үзүүлэх итгэлийн түвшин өөр өөр байна. Тухайлбал гэр бүл, найз нөхөд, нийгмийн цөөнх буюу ижил хүйстний хүмүүст үзүүлэх итгэл боловсрол өндөртэй оролцогчдод илүү өндөр байна.

Дүрс 4. Эмч нарын бүлэг өөр бүлгийн хүмүүст итгэх итгэлийн түвшинг улсын дундажтай харьцуулсан (10-бүрэн итгэдэг; 0-огт итгэдэггүй) үр дүн




Амьдралын сэтгэл ханамж

Амьдралын сэтгэл ханамж гэдэг нь хүмүүс өөрсдийн амьдралаа хэрхэн үнэлж буй хэмжүүр юм. Уг үзүүлэлтийг тодорхойлохдоо “Кантрилийн шатлал” буюу оролцогчдыг 0-ээс 10 хүртэлх гишгүүртэй шат төсөөлж өөрийн амьдралыг аль шатанд байгааг үнэлүүлдэг.

Амьдралын түвшинг 10 гишгүүртэй шатаар зүйрлэвэл та өөрийн амьдралыг аль гишгүүр дэр байна гэж бодож байна вэ?

- Эмнэлгийн байгууллагын ажилтнууд одоогийн амьдралаа 10 гишгүүртэй шатаар зүйрлэхдээ 5.44 буюу 5 - 6 дугаар гишгүүрийн хооронд байгаагаар, харин 5 жилийн өмнөх амьдралаа 6.06 гэж үнэлж, 5 жилийн дараах амьдралаа 7.42 гэсэн байдлаар төсөөлсөн байна.
- Монгол Улсын дунджаар иргэд 5 жилийн өмнөх үнэлгээнээс одоогийн нөхцөл байдлаас өндөр, ирээдүйн 5 жилийн нөхцөл байдлаа одоогийн нөхцөл байдлаас өндөр төсөөлсөн үр дүн харагддаг. Харин эмч нарын хувьд одоогийн нөхцөл байдлаа ирээдүйн болон өмнөх нөхцөл байдлын аль алинаас доогуур үнэлж байгаа нь онцлогтой байна.

Дүрс 5. Амьдралын сэтгэл ханамжийг цаг хугацааны интервалаар харуулсан үр дүн





Амьдралын сэтгэл ханамж

Бүх зүйлсийг хамруулан авч үзвэл та өөрийгөө хэр зэрэг аз жаргалтай гэж хэлэх вэ?

(0= Огт аз жаргалгүй; 10= Бүрэн дүүрэн аз жаргалтай)

- Улсын дундаж дүнг харвал Монголчууд өөрсдийн амьдралдаа нэлээд сэтгэл хангалуун (7.96) байдаг нь харагддаг. Харин эмнэлгийн байгууллагад ажиллагсдын хувьд өөрсдийн амьдралдаа сэтгэл ханамжтай, аз жаргалтай байгаа байдал улсын дунджаас ялимгүй бага (7.19) байв.
- Хэдийгээр үр дүнг дундчилж авч үзэхэд төдийлөн зөрүү гарахгүй байгаа боловч эмнэлгийн байгууллагад ажиллагсдын “бүрэн дүүрэн аз жаргалтай” ангилал руу дөхсөн шкал буюу 8, 9, 10 гэсэн хариултуудыг сонгосон байдал улсын дундажтай харьцуулахад эрс бага байна.

Дүрс 6. Судалгаанд оролцогчдын хариултын тархалт (хувиар)



Амьдралын олон талт байдлын үнэлгээ

Амьдралын олон талт байдлын үнэлгээ гэдэг нь хүмүүс өөрийн амьдралынхаа талаар эргэцүүлэн бодож, амьдрал нь хэрхэн өрнөж байгаа талаар үнэлүүлэх асуултууд юм. Амьдралын олон талт байдлын сэтгэл ханамжийг үнэлэх 8 асуулт асуусан ба үр дүнг дор харуулав.

- Эмнэлгийн байгууллагад ажиллагсад гадаад орчин болон хувийн орчиндоо хэрхэн үнэлэлт өгч байгаа нь ялгаатай байв. Судалгаанд хамрагдагчдын дийлэнх нь гадаад орчин болох Монголын улс төрийн нөхцөл байдал (2.81), эдийн засгийн нөхцөл байдал (3.38)-д сэтгэл ханамж муу байв. Эсрэгээр өөрийн гэр бүл, ажил мэргэжилдээ хамгийн өндөр сэтгэл ханамжтай байдаг болохоо илэрхийлжээ.

Дүрс 7. Амьдралын олон талт байдлын үнэлгээний үр дүн




Амьдралын утга учрын талаарх үнэлгээ

Амьдралын утга учрын талаарх үнэлгээ гэдэг нь зөвхөн аз жаргалтай байдал, эерэг сэтгэл хөдлөлөөс илүү өргөн хүрээний субъектив сайн сайхан байдлыг илэрхийлдэг. Хүмүүс амьдралын утга учир болон зорилгоо хэрхэн мэдэрч байгаа, сэтгэл зүйн хувьд хэр хангалуун байгаа талаар асуудаг. Амьдралын утга учрын талаарх үнэлэх 8 асуулт асуусан ба үр дүнг дор харуулав.

- Эмч нарын бүлгийн сэтгэл зүйн ерөнхий шинж хандлага харьцангуй өндөр, сэтгэл ханамжтай гэсэн үр дүн гарсан. Тэр дундаа өөрсдийн “бие даасан байдал” (өөрийнхөө төлөө шийдвэр гаргах, амьдралын утга учир зорилгоо тогтоох эрх чөлөө,)-даа хамгийн сэтгэл ханамжтай гэсэн үнэлгээ өгсөн байна.
- Харин сүүлийн үеийн нөхцөл байдалтай холбоотой бодомжуудад сөрөг хариулт өгсөн хүмүүсийн тоо бага зэрэг өсөж байгаа нь ажиглагдсан.

Дүрс 8. Амьдралын утга учрын талаарх үнэлгээ



Ном зүй

- IRIM (2020), "Монголын нийгмийн сайн сайхан байдлын судалгаа: Ахмад настнуудын нийгмийн сайн сайхан байдал" Улаанбаатар. IRIM судалгааны хүрээлэн
- IRIM (2018), "Монголын нийгмийн сайн сайхан байдлын судалгаа" Улаанбаатар. IRIM судалгааны хүрээлэн
- Aldar, Dolgion & Chultemsuren, Tamir (2015). Defining social cohesion research design and indicators: in the case of Mongolia. National University of Mongolia
- Clifton, Jon (2017). The Happiest and Unhappiest Countries in the World. Gallup World Poll. <https://news.gallup.com/opinion/gallup/206468/happiest-unhappiest-countries-world.aspx>
- Fukuyama, Francis (1995). Trust: the social virtues and the creation of prosperity. New York. Free Press.
- Helliwell, J., Layard, R., & Sachs, J. (2017). World Happiness Report 2017. New York. Sustainable Development Solutions Network
- Inglehart, R., C. Haerpfer, A. Moreno, C. Welzel, K. Kizilova, J. Diez-Medrano, M. Lagos, P. Norris, E. Ponarin & B. Puranen et al. (eds.). 2014. World Values Survey: Round Six - Country-Pooled Datafile Version: www.worldvaluessurvey.org/WVSDocumentation-WV6.jsp. Madrid: JD Systems Institute.
- Jenson, Jane (1998). Mapping Social Cohesion: The State of Canadian Research, Canadian Policy Research Networks
- Larsen, Christian (2014). Social cohesion: Definition, measurement and developments <https://pdfs.semanticscholar.org/e2b4/6f29845743b214a522b3000eabca50052c0c.pdf>
- OECD (2013). OECD Guidelines on Measuring Subjective Well-being. OECD Publishing
- Stanley, Dick (2003). What Do We Know about Social Cohesion: The Research Perspective of the Federal Government's Social Cohesion Research Network. The Canadian Journal of Sociology Vol. 28, no. 1, 5-17
- Uslaner, E.M. (2007). The Generalized Trust Questions in the 2006 ANES Pilot Study
- Veenhoven, Ruut (2008). Sociological theories of Subjective Well-Being In: Michael Eid & Randy Larsen (Eds), "The Science of Subjective Well-being: A tribute to Ed Diener". New York. Guilford Publications